



АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ

АНГИ – 11

Аялал

- Аялал
- Зугаалга
- Гэр бүл
- Найз нөхөд
- Зуслан
- Зуны амралт

Аян замд

- Аялал зугаалгаар явах
- Байгалийн үзэсгэлэнт газар
- Түүх соёлын газар
- Элдэв сонин зүйл
- Адал явдал

Аян замын тэмдэглэл

- Бичиж тэмдэглэх
- дурсамж

Өмнийг зорьсон тэмдэглэл

- Зуны амралт эхлэв. Бид гэр бүлээрээ ах дүү хамаатан садан дээрээ очихоор өмнийн цэнхэр говийг зорилоо. Манай аав ээж говьд төрсөн. Говийн хүмүүс гэж ярих их дуртай. Харин би УБ-т төрсөн болохоор говийг төдийлөн сайн мэдэхгүй, зөвхөн аав ээжийнхээ ярианаас л жаахан мэднэ. Харин энэ удаа нүдээр үзэх боломж гарсан юм.
- Дархан цаазтай Ёлын амд очлоо. Говийн аагим халуун шарсан тэр нэгэн уулын ам руу ороход л сэрүү татан, ургамлын сайхан үнэр хамар цоргиж байлаа. Ёлын ам нь 2815 метр өндөр, зузаан мөстэй, төв хэсэгтээ 200 орчим метр өндөр цавчим элгэн хадан ханатай юм байна. Говьд тийм сүрлэг сайхан уул байдаг гэж би зүүдлээ ч үгүй явсан болохоор өөрийн эрхгүй байгалийн сайхнаар бахархах сэтгэл төрсөн юм. Бид тэндээсээ цааш явсаар Хонгорын голд очлоо. Тэнд юу үзсэн гэж санана.Элсэн уул. Би уулыг хад чулуу, өндөр сүрлэг хадан хясаа байдаг гэдгийг л мэддэг байсан.

ҮРГЭЛЖЛЭЛ

- ... Гэтэл элсэн уулын дээгүүр хөл нүцгэн явахад торго шиг зөөлхөн элс улыг минь илэх мэт санагдаж байв. Энэ уул нь Сэврэй, Зөөлөн уулын араар 180 орчим үргэжилдэг төдийгүй 3-15 метр өргөн. 15-30 метр өндөр сул элсэн уул юм байна. Бас нэг сонин юм нь говийн зэрэглээ байлаа. Би түүнийг далай байна гэж хэлж тэдний инээдийг хүргэж билээ.

Бичихдээ

- Хэзээ? Хаана? Юу? Хийж явснаа бодох
- Онцгой санагдсан зүйлийн талаар бич
- Тэмдэглэл уг зүйлийн танилцуулга зэргийг олох
- Бичих дарааллын төлөвлөгөө гаргах
- Бичсэн эхийг засан сайжруулах хэрэгтэй

АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ

- Хэрэг явдал хэзээ? Хаана? болж байгаа нь тодорхой байх
- Тухайн үзсэн харсан зүйлийн тухай хууч үг, домог ярианы хэсгээс бичих
- Үнэн бодит мэдээллээр санаагаа улам баяжуулах
- Бичигчийн өөрийн санаа бодол туссан байх
- ТМ, сонирхол татахуйц байх

АНГИ - 11

- Аяласан газрын нөхцөл байдлыг мэдрэмж, сэтгэгдэлтэйгээ холбон бичих

ОНЦЛОГ

- Гадаад улс орон, эх орныхоо өнцөг булан бүрээр аялж, ажигласан шинэ сонин зүйл, хөгжил, ард түмний аж байдал, нийгмийн байдлын онцлог, байгалийн өвөрмөц тогтоц, үзэгдэл, үйл явдал зэргийг сонирхуулах, тм зорилгоор бичдэг.
- Сэтгэгдэл, тайлбар, сэтгэлийн өнгө аяс, үнэлэлт дүгнэлтийг чөлөөтэй бичнэ.

ТЭМДЭГЛЭЛ

- Үйл явдлыг тоочин тайлбарлах
- Орчныг зураглан тоочиж тайлбарлах
- Үзэл бодлоо илэрхийлэх
- Уран дүрслэл, хэлц үг хэллэг хэрэглэх

Хөрөг

- Зохиолч ямар нэгэн бие хүний амьдралд тохиолдсон гоц гойд зүйл, амжилт ололтыг тодруулан гаргахдаа тэр хүний зан төлөв, төрх байдал, үйл ажиллагаа зэргийг өөрийн ажиглалт, судалгаанд үндэслэн дүрслэн бичсэн нийтлэлийг хэлнэ.

Гадаад байдал

- Тухайн хүний гадаад төрх болох нүүр царай
- Үсний өнгө засалт
- Хувцаслалт
- Өндөр, нам
- Гар хөл
- Дуууны өнгө
- Нямбай эсэх
- Бусдаас ялгарах онцлог зэргийг дүрсэлнэ.

ДОТООД ШИНЖ

- Уг хүний тухайн нөхцөл байдалд хэрхэн хандаж байгаа хандлага
- Сонирхол
- Дадал зуршил
- Бодол санаа
- Сэтгэл хөдлөл зэрэг дотоод ертөнцийг нээн илрүүлж бичнэ.
- Хөрөг найруулалд цг хүнтэй уулзсан орчныг дүрслэн бичих нь баатрынхаа дотоод ертөнцийг илрүүлэн гаргахад тустай.

АНХДАГЧ

- 1974 онд холын Туркийн Стамбул хотноо болсон дэлхийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээний үеэр Монголын спортын түүхэнд үл мартагдах чухал үйл явдал тохиож Өвөрхангай аймгийн Хархорин сумын уугуул өдгөөгийн хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин Зэвгийн Ойдов дэлхийн аваргын алтан медалийг эх орондоо анх авчирсан билээ. Орхоны хөндийгн өгсөж, уруудаж, уйлж дуулж, гуньж баярлаж, догширч зөөлөрч эрийн цээнд хүрсэн 26 настай ер бусын шөрмөслөг, ер бусын идэр жавхлант энэ монгол эр тэнд чухам ямархан ялалт байгуулж олныг бишрүүлсэн гэж сананам.
- Түүний барилдааны ур чадварын талаар үе тэнгийнхэн нь өдгөө ч ам уралдуулан ярьдаг юм билээ. Тэрбээр учраагийнхаа биед аяархан хүрч аясыг нь дагаж байснаа гэнэт л барилдааны санаачлагыг гартаа авч угсраа олон мэхээр сэхээ самбаа өгөлгүй барилддаг байсан гэнэ....

ҮРГЭЛЖЛЭЛ

- ... Хавирна, хавсарна, дэгээднэ, өсгийднө, өлмийднө болохгүй бол тохно, баруун зүүн хөлийн аль нэгэнд нь суух юм уу, эсвэл давуулаад гуядна. Тонгорох барьцгүй атлаа тонгорно. Санаанд орохгүй мэхийг дараа дараагаар хийнэ.
- Зүйрлэвэл, түүний барилдах нь эгээтэй л мөсөн чихэр хүлхэх мэт ээ. Учраадаа халгаатай хатуу ч үзэгчдийн сэтгэлийн шүлсийг асгаруулсан дэндүү амттай, тансаг. 1976 оны Монрелийн олимпын мөнгөн медальт золбоолог энэ монгол өрсөлдөгчийнхөө толгойг уургалсан байдлаас хөлд ордог дархан мэхээ өөрийн нэрээр дэлхийн бөхийн холбоонд данслуулж чадсан билээ. Ийм сайхан хүчтэнг халхын хавтгайгаас хайгаад хэн ч үл олно.

◦

Ц. Галбадрах